



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А/697

Баруун-Урт сум

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3, 10.1.5, 12 дугаар зүйлийн 12.1, 16 дугаар зүйлийн 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Наран сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Ц.Тулга захиралтай “ББТБ” ХХК-ийн “Хишиг” хүнсний дэлгүүр, Баруун-Урт сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй М.Пүрэвдорж захиралтай “Дэнжийн төгс хүнс” ХХК-ийн “Ганга” хүнсний дэлгүүр, Баруун-Урт сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Т.Ганцэцэг захиралтай “Өрнөх цангилиг” ХХК-ийн “Sky” караоке паб, Мөнххаан сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Г.Гэндэнсэлэнгэ захиралтай “Ашид дэлгэр заяа” ХХК-ийн “Гранд” зоогийн газар, Эрдэнэцагаан сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Алтанзаяа захиралтай “Тогтуун ирээдүй” ХХК-ийн “Далай булаг” хүнсний дэлгүүр, Баруун-Урт сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй П.Сайханчулуун захиралтай “Саврай” ХХК-ийн “Смайл” зоогийн газар, Сүхбаатар сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Ш.Дашдорж захиралтай “Жавхлант Агро” ХХК-ийн “Наадаан Ресорт” караоке, зоогийн газарт спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай сунгасугай.

2. Тусгай зөвшөөрөл сунгагдсан болон шинээр олгогдсон аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Х.Энхцэцэг), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа

2222614 1

Б.Гантулга), Мэргэжлийн хяналтын газар (С.Нямжав), Стандарт хэмжил зүйн хэлтэс (Д.Эрдэнэбат), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийг мөрдөн ажиллахыг дээрх аж ахуй нэгжүүдийн захирлуудад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ